



Нүүрсний хэлтэс

# Нүүрсний зах зээлийн өнөөгийн байдал


(Хятад улс)

ЭХ СУРВАЛЖ: <http://en.sxcoal.com/501/106090/DataShow.html>

2014

## Хятад улсын Коксжих нүүрсний үнэ

Нүүрсний зах зээлд нөөц өсөж, эрэлт бага байгаа боловч коксжих нүүрс олборлогчид бүрлуулалтаа нэмэгдүүлэхийг хичээж байгаа ба нүүрсний гол олборлолтын хэсэг болох Шанси мужид коксжих нүүрсний үнэ уналттай байна.



## Тоон үзүүлэлт

2014 оны 7 сарын 28 байдлаар Хятадын коксжих нүүрсний үнэ 5.82 хувиар унаж, Жинтанг мужийн импортын коксжих нүүрсний үнийн индекс буюу Австралийн хатуу коксжих нүүрс 632 юань/тонн үнэтэйгээр сүүлийн хоёр 7 хоногт тогтвортой байна.



## Зах зээлийн сүүлийн үеийн байдал

Төмөрлөгийн үйлдвэрүүд болон коксын үйлдвэрүүд дэх коксжих нүүрсний нөөц төмөрлөгийн үйлдвэрийн үйл ажиллагаатай хамааралтайгаар өссөөр байгаа ба дунджаар 16 хоногийн нөөцтэй байна.

Өнгөрсөн долоо хоногийн байдлаар Шанси мужийн нүүрс олборлолтын гол хэсгүүдэд коксжих нүүрсний үнэ 10-40 юань/тонн-оор унасан байна. Ихэнх нүүрсний уурхайнуудын бэлэн нүүрсний нөөц их байгаа боловч төмөрлөгийн болон коксын үйлдвэрүүдийн эрэлт харьцангуй бага байна. Гэвч дийлэнх уурхайнууд нүүрс олборлолтоо хэвийн хэмжээнд явуулж байна.

Тангшан мужийн төмөрлөгийн болон коксын үйлдвэрүүд нүүрс олоблогчдыг үнээ буулгахыг шаардаж байгаа учраас төмөрлөгийн үйлдвэрүүдэд нийлүүлдэг дээд зэрэглэлийн угаасан коксжих нүүрсний үнэ 1000 юань/тонн- оос доош орсон ба цаашид ч унах төлөвтэй байна гэж орон нутгийн нүүрс угаах үйлдвэрүүд мэдээлжээ.

Хэбэй мужийн эцсийн худалдан авагчдын эрэлт багассанаас шалтгаалж коксжих нүүрсний үнэ 10-20 юань/тонн-оор унасан байна. Орон нутгийн зах зээлд дэмжлэг хангалтгүй, төмөрлөгийн болон коксын үйлдвэрүүд 10 хоногийн хангалттай нөөцтэй цаашид худалдан авах төлөвгүй байна.

Янжү мужийн нүүрсний уурхай үнээ буулгахаар мэдээлсэнтэй хамааралтайгаар тус муж дахь коксжих нүүрсний үнэ 10-30 юань/тонн-оор унасан байна. Үнээ буулгасан ч нүүрсний борлуулалт нэмэгдэх хандлага ажиглагдахгүй байна. Томоохон төмөрлөгийн үйлдвэрүүд өдөр хүхрийн агуулгатай нүүрсний хэрэглээг багасагах зорилготой учраас бага хүхрийн хийн агуулгатай нүүрсний худалдан авалт өсөх магадлалтай байна.

Импортын зах зээл дээр 1 болон 2 дугаар зэрэглэлийн хатуу коксжих нүүрсний захиалга бага буюу хязгаарлагдмал байна. Ямарч худалдааны гэрээ тохролцоо өнгөрсөн хэдэн 7 хоногийн туршид хийгдээгүй.Импортын материалын үнийн давуу тал эрчимтэйгээр буурч цаашид дотоодын зах зээл дээр унах хандлагатай байна.

## Хэтийн төлөв

Кокс болон төмөрлөгийн зах зээлийн уналтаас шалтгаалж богино хугацаанд Хятадын зах зээл дэх коксжих нүүрсний эрэлт багасаж, борлуулахад бэлэн нүүрсний нөөц нэмэгдэнэ. Эцсийн хэрэглэгчид үйлдвэрлэлийн зардлаа багасгахаар хичээж ажиллаж буй учраас хятадын коксжих нүүрсний зах зээл үнийн уналтын дарамтанд орох төлөвтэй байна.



### Хятадын коксжих нүүрсний импорт 2014 оны 6 сарын байдлаар

Импорт	2014.0 6 сар, Мян онн	2013 оны 6 сараас(+/- %)	2014 оны өссөн дүн, Мян тонн	2013 оноос (+/- %)
Нийт	25.040	12.04	159.850	0.92
Антрацит	2497	-30.17	17.033	-19.14
Коксжих нүүрс	5.717	21.70	30.962	-12.34
Эрчим хүчний нүүрс	9.710	34.67	61.310	19.07
Хүрэн нүүрс	5.895	36.34	36.215	20.86

## Хятад улсын нүүрсний импорт

Олборлолт	2014 он 6 сар		2014 онд	
	Хэмжээ (1,000 тонн)	Үнэ (US\$1,000)	Хэмжээ (1,000 тонн)	Үнэ (US\$1,000)
<b>Нийт</b>	19,154.12	1,573,317.00	123,637.50	10,735,280.00
Австрали	7,805.99	742,445.00	45,630.79	4,638,045.00
Белги	0.00	0.00	0.69	178.63
Канад	736.02	86,250.73	3,736.93	478,997.90
Чили	0.00	0.00	147.66	7,582.17
Колумб	0.00	0.00	104.92	12,560.95
Индонези	3,685.36	257,496.70	28,212.91	2,034,752.00
Иран	0.00	0.00	21.00	1,474.43
Киргиз	0.64	12.76	2.02	41.60
БНАСАУ	1,398.86	103,109.10	7,437.28	575,195.30
Казакстан	1.90	212.07	33.74	4,446.37
Лаос	0.00	0.00	10.13	501.26
Мянмар	0.40	11.02	0.60	16.54
<b>Монгол</b>	2,135.52	111,970.30	9,646.61	512,100.50
Бусад	3389.4	271,809	28,652.26	2,469,391.39

Тайлбар: Нийт=Нүүрсний төрлийн бүх бүтээгдэхүүн

Хянасан: АМГ- н Нүүрсний хэлтсийн дарга Б. Алтсүх  
 Нүүрсний хэлтсийн ҮТГ-н дарга Т.Буянбат  
 Боловсруулсан: Мэргэжилтэн Т. Алтангэрэл

Э. Батсүх